

Маргааны товч

Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг дарга 2003 оны 118 дугаар захирамжаар “Дарханмах экспо” ХХК-д үйлдвэрийн байр, хашааны газрын зориулалтаар эзэмшүүлсэн 88,000 м.кв талбай бүхий газрыг Дархан-Уул аймгийн Засаг дарга 2010 оны 311 дүгээр захирамжаар “Русмяспром” ХХК-д шилжүүлжээ.

Улмаар аймгийн Засаг дарга “Русмяспром” ХХК-ийн хүсэлтийн дагуу 2013 оны 135 дугаар захирамжаар “Чингисхаан банк” ХХК-д, 2015 оны А/192 дугаар захирамжаар “Чингисхаан банк” ХХК-аас “Русмяспром” ХХК-д тус тус шилжүүлсэн, “Русмяспром” ХХК-ийн оноосон нэр “Дархан мах корпораци” ХХК болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2018 оны А/276 дугаар захирамжаар үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлжээ.

Нэхэмжлэгчээс “Дархан-Уул аймгийн Засаг дарга 2010 онд “Дарханмах экспо” ХХК-аас “Русмяспром” ХХК-д шилжүүлэхдээ газрын хэмжээг нэмэгдүүлээгүй атлаа гэрээ, гэрчилгээгээр 88,000 м.кв газрын хэмжээг 98,470 м.кв болгон нэмэгдүүлсэн нь миний эзэмших газартай давхцалтай, хууль бус” гэх үндэслэлээр маргажээ.